



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛЫН САЙД**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,  
Утас: 26-22-27, И-мэйл: letter@moe.gov.mn  
Вэб сайт: moe.gov.mn

2026.03.26 № 1а/1540

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН О.БАТНАЙРАМДАЛ ТАНАА**

Таны ирүүлсэн Боловсролын зээлийн сангийн  
үйл ажиллагааны талаарх мэдээлэл буюу тавьсан  
асуултын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт *12* хуудастай.



**П.НАРАНБАЯР**

**1426130616**

## БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

**Асуудал 1.** Боловсролын зээлийн сангийн зээл, тэтгэлгээр гадаад болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцсан суралцагчдын гэрээг лүгнэсэн эсэх, гэрээний үүрэг биелүүлээгүй асуудлыг шийдвэрлэж, алдаа зөрчлийг арилгасан талаарх хяналт, шалгалтын мэдээллийг дараах асуудал тус бүрээр:

**1.1** Ерөнхий сайдын нэрэмжит буюу Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрөөр 2022–2026 онд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад сурсан, суралцаж буй суралцагчдын гэрээний хэрэгжилт, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, гэрээний үүрэг биелүүлээгүй суралцагчдын тоо, олгосон санхүүжилтийн нийт дүн, хийсэн хяналт, шалгалтын талаар;

Засгийн газрын тэтгэлэг (Ерөнхий сайдын тэтгэлэг)-ийн хөтөлбөрийн хүрээнд 2022–2026 онд нийт 92 суралцагчид 15.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Үүнээс магистрын түвшний 79, докторын түвшний 3 суралцагч тэтгэлэгт хамрагдсан бөгөөд 10 суралцагч тэтгэлгээс татгалзсан байна.

2025 оны байдлаар гэрээний үүргийн биелэлтийг дүгнэхэд 32 гэрээг сунгаж, 2 гэрээг түдгэлзүүлсэн байна. Гэрээг түдгэлзүүлсэн шалтгаан нь “өмнөх улирлын голч дүн авбал зохих үнэлгээний 75 хувиас доошгүй байх” шалгуурыг хангаагүй.

**1.2.** Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээр 2010–2026 онд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад сурсан, суралцаж буй суралцагчдын гэрээний хэрэгжилт, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, гэрээний үүрэг биелүүлээгүй суралцагчдын тоо, олгосон санхүүжилтийн нийт дүн, хийсэн хяналт, шалгалтын талаар;

Он	Суралцагчдын тоо /давхардсан тоогоор	Олгосон санхүүжилт /ам. доллар/
2020	21	842,978.9
2021	39	807,428.94
2022	40	936,193.899
2023	41	844,680.817
2024	53	864,216.471
2025	77	376,301.47
	<b>271</b>	<b>4,671,800.2</b>

“Засгийн газар хоорондын тэтгэлэг”-ээр АНУ-ын Фульбрайт, Английн Чевнинг хөтөлбөр, Польш, Франц, Куба Улсад суралцагчдад амьжиргааны зардлын тэтгэлгийг олгосон.

*Гэрээний үүргийн биелэлт дүгнэсэн товчоо /2025 оны эцсийн байдлаар/:*

№	Үзүүлэлт	Суралцагчийн тоо	Гэрээний заалт
1	Гэрээ сунгах /Санхүүжилт олгосон/	92	2022.12.20-ны өдрийн А/544, А/256 тоот хамтарсан тушаалын 5-р хавсралт гэрээний 4.1-р заалт, 2024.06.14-ны өдрийн А/301 тоот тушаалын 3-р хавсралт гэрээний 4.4-р заалт, 2025.12.03-ны өдрийн А/571, А/212 тоот хамтарсан тушаалын 2-р хавсралт гэрээний 3.1, 5.1-р заалт
2	Санхүүжилт олгогдоогүй	114	Санхүүжилт олгогдоогүй болно.
3	Төгссөн	7	2022.12.20-ны өдрийн А/544, А/256 тоот хамтарсан тушаалын 5-р хавсралт гэрээний 2.1, 2.2.4-р заалт, 2024.06.14-ны өдрийн А/301 тоот тушаалын 3-р хавсралт гэрээний 1.3, 2.2.2-р заалт, 2025.12.03-ны өдрийн А/571, А/212 тоот хамтарсан тушаалын 2-р хавсралт гэрээний 1.2-р заалт
<b>Нийт</b>		<b>213</b>	-

2025 оны 2 дугаар хагас жилийн байдлаар 92 суралцагчийн санхүүжилт олгогдсон ба санхүүжилт олгогдоогүй 114 суралцагчийн хувьд сайдын тушаалд заасан суралцах хугацаа дуусаагүй бөгөөд Элчин сайдын ямаар дамжуулан ирүүлсэн суралцаж буй дүн, тодорхойлолтыг үндэслэн дараагийн улирлын санхүүжилтийг олгодог.

Засгийн газар хоорондын гэрээний хүрээнд нийт 47 төгсөгчийн (2022 онд төгссөн 23, 2023 онд төгссөн 19, 2024 онд төгссөн 5 төгсөгч) ажил эрхлэлтийн судалгааг хийсэн.

Засгийн газрын тэтгэлгээр 2022–2025 онд төгссөн ажил эрхэлж буй төгсөгчдийн ажиллаж буй байгууллагын төрлийг дараах байдлаар ангилж байна. Үүнд: Монгол Улсад ажиллаж буй 24 ( төрийн байгууллагад 5, хувийн хэвшилд 18, төрийн бус байгууллагад 1), эх орондоо буцаж ирээгүй, гадаадад ажиллаж буй 7, төгссөн бүртгэл хийлгээгүй 14, гэрээний хугацаанд төгсөөгүй 2 иргэн байна.

**1.3. Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 1997–2026 онд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад сурсан, суралцаж буй суралцагчдын гэрээний хэрэгжилт, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, гэрээний үүрэг биелүүлээгүй суралцагчдын тоо, олгосон санхүүжилтийн нийт дүн, хийсэн хяналт, шалгалтын талаар;**

**1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг:**

*Гэрээний үүргийн биелэлт дүгнэсэн товчоо /2025 оны эцсийн байдлаар/:*

№	Үзүүлэлт	Суралцагчийн тоо	Санхүүжилтийн дүн, төг	Гэрээний заалт
1	Гэрээ сунгах	918	32,703,494,405.54	2022.12.20-ны өдрийн А/544, А/256 тоот хамтарсан тушаалын хавсралт гэрээний 4.1-р заалт, 2024.06.14-ны өдрийн А/301 тоот тушаалын хавсралт гэрээний 4.4-р заалт, 2025.12.03-ны

				өдрийн A/511, A/212 тоот хамтарсан тушаалын хавсралт гэрээний 5.1-р заалт
2	Гэрээ түдгэлзүүлэх	19	156,505,296.54	2022.12.20-ны өдрийн A/544, A/256 тоот хамтарсан тушаалын хавсралт гэрээний 2.1.5-р заалт, 2024.06.14-ны өдрийн A/301 тоот тушаалын хавсралт гэрээний 4.1, 4.2-р заалт, 2025.12.03-ны өдрийн A/511, A/212 тоот хамтарсан тушаалын хавсралт гэрээний 5.2-р заалт
3	Санхүүжилт зогсоосон, татгалзсан	72	234,554,157.83	2022.12.20-ны өдрийн A/544, A/256 тоот хамтарсан тушаалын хавсралт гэрээний 4.2-р заалт, 2024.06.14-ны өдрийн A/301 тоот тушаалын хавсралт гэрээний 4.11, 4.12-р заалт, 2025.12.03-ны өдрийн A/511, A/212 тоот хамтарсан тушаалын хавсралт гэрээний 5.4-р заалт
4	Төгссөн	8	-	2022.12.20-ны өдрийн A/544, A/256 тоот хамтарсан тушаалын хавсралт гэрээний 1.2, 2.2.4-р заалт, 2024.06.14-ны өдрийн A/301 тоот тушаалын хавсралт гэрээний 1.3, 2.2.8-р заалт, 2025.12.03-ны өдрийн A/571, A/212 тоот хамтарсан тушаалын хавсралт гэрээний 1.2, 2.2.9-р заалт
5	Суралцаж эхлээгүй түр хүлээж байсан.	39	-	Санхүүжилт олгогдоогүй.
<b>Нийт</b>		<b>1056</b>	<b>33,094,553,859.91</b>	-

Тайлбар:

**Татгалзсан:**

Хөтөлбөрөөс өөрсдийн санаачилгаар татгалзсан 19 суралцагчид нийт **162.81 сая төгрөгийн** санхүүжилт олгогдсон байна.

**Санхүүжилт зогсоосон:**

Дараах шалтгаанаар 53 суралцагчийн санхүүжилтийг зогсоосон. Үүнд:

- Суралцагч гэрээнд заасан сургууль эсхүл мэргэжлээ сольсон
- Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сургуулиас гарсан, хасагдсан
- Тухайн улс оюутан элсүүлээгүй,
- Гэрээ байгуулаагүй байж суралцаж эхэлсэн,

Дээрх 53 суралцагчид нийт **71.74 сая төгрөгийн** санхүүжилт олгогдсон байна.

**Гэрээ түдгэлзүүлсэн:**

- Суралцагч дүнгийн шаардлага хангаагүй
- Сургалтын байгууллагаас хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөө авсан

Дээрх 19 суралцагчийн гэрээг түдгэлзүүлсэн бөгөөд нийт 156.5 сая төгрөгийн санхүүжилт хамаарч байна. Эдгээр суралцагчидтай тооцоо нийлсэн акт болон гэрээ дүгнэсэн актыг үйлдэн, гарын үсгээр баталгаажуулсан.

**Төгссөн:**

Тэтгэлгээр суралцаж байсан 8 суралцагч 2025–2026 оны хичээлийн жилийн II улиралд төгссөн. Эдгээр суралцагчтай холбогдон “Гадаадад суралцагчид Монгол улсын ерөнхийлөгч болон ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох гэрээ”-ний 1.2, 2.2.4, 2.2.5, заалтуудад зааснаар төгсөлтийн бүртгэлд хамрагдах, 1 жилийн дотор гэрээний гуравдагч тал болох харьяалагдах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид ажиллах тухай мэдэгдэл хүргүүлсэн.

**Суралцаж эхлээгүй /түр хүлээгдэж буй/:**

2025 онд шинээр гадаадад суралцах тушаал гарсан иргэдийн хувьд тухайн сургуулиас ирэх албан хүсэлт, баталгааг хүлээж байгаа.

**2. Монгол Улсын “Ерөнхийлөгчийн бэлтгэл хөтөлбөрийн тэтгэлэг”**

Нийт 2025-2026 оны хичээлийн жилийн 1-р улиралд Боловсролын сайдын тушаалуудаар 319 суралцагчийг дотоодын бэлтгэл хөтөлбөрт суралцуулах тушаал гарсан.

*Гэрээний үүргийн биелэлт дүгнэсэн товчоо /2025 оны эцсийн байдлаар/*

№	Үзүүлэлт	Суралцагчийн тоо	Санхүүжилтийн дүн, төг	Тушаал
1	Гэрээ сунгах	304	945,842,900.00	Боловсролын сайдын 2024.11.21-ны өдрийн А/203 тушаал
<b>НИЙТ</b>		<b>304</b>	<b>945,842,900.00</b>	

Мөн 2024-2025 оны хичээлийн жилд гэрээ сунгах МУИС-ийн 200 суралцагчдад ШУТИС-ийн 100 суралцагчийн санхүүжилтийг 2025 оны 12 сард олгогдсон. Боловсролын сайдын 2025 оны 10 дугаар сарын 17-ний өдрийн А/505 тушаалаар 2025-2026 оны хичээлийн жилийн бэлтгэл хөтөлбөрт 328 суралцагч сурахаар батлагдсан. Бэлтгэл хөтөлбөрт хамрагдаж байгаа нийт 322 суралцагчийн 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилт 2026 оны 1 сард олгогдсон.

**3.Сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл**

Засгийн газрын 2025 оны “Журам шинэчлэн батлах тухай” 215 дугаар тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам”-ын 11.8, 11.9, 11.10, 12.3.2, 12.3.6 дахь заалтыг тус тус үндэслэн дэлхийн шилдэг их сургуульд бакалаврын хөтөлбөрт суралцагчдын гэрээний биелэлтийг дараах байдлаар дүгнэж байна.

№	Үзүүлэлт	Суралцагчийн тоо	Санхүүжилтийн дүн, төг
1	Гэрээ сунгах	166	13.9 тэрбум
2	Гэрээ түдгэлзүүлэх	30	

3	Гэрээ цуцалсан	2	40,446.19\$
Нийт		198	

**Гэрээ сунгах:** Дэлхийн шилдэг их сургуульд боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр бакалаврын хөтөлбөрт Боловсролын сайдын 2023 оны А/293, 2024 оны А/04, А/71, 2025 оны А/356 тоот тушаалаар суралцаж буй нийт 166 суралцагчийн гэрээг сунгаж 3,928,665.37 ам доллар буюу 13.9 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

**Гэрээ түдгэлзүүлэх:** Тухайн улирлын сургалтын төлбөрөө хувиараа төлсөн, өмнөх улирлын голч дүнгийн шаардлага хангаагүй, хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөө авсан, хувиараа сургалтын төлбөрөө төлөх хүсэлт өгсөн болон бусад шалтгаанаар дараах суралцагчид гэрээ түдгэлзүүлсэн байна.

**Гэрээ цуцалсан:** Тайлант хугацаанд өөрийн хүсэлтээр дараах суралцагчид гэрээ цуцлах хүсэлт өгсөн байна.

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Олгосон санхүүжилт /ам,доллар/
1	Батболд Түмэнхүслэн	██████████	9,366.85
2	Халиун Энгүн	██████████	31,079.34
Нийт			40,446.19

Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 2024–2026 онд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний буцалтгүй тусламж"-аар сурсан суралцагчдын тоо, санхүүжилтийн судалгаа

№	Он	Хөтөлбөр	Суралцагчдын тоо	Санхүүжилт (ам доллар)
1	2024 он	ХБИ буцалтгүй тусламж	2	6,089,385.47
2	2025 он		6	24,748,603.35
3	2026 он			
Дүн			8	30,837,988.83

Гадаадын дээд боловсролын байгууллагад зээлээр 1997–2018 онд суралцаж төгссөн 431 иргэний хөдөлмөр эрхлэлтийн судалгааг хийсэн байна. Судалгааны дүнгээр 210 иргэн төрийн байгууллагад, 204 иргэн хувийн хэвшилд тус тус ажиллаж байна.

Мөн Засгийн газар хоорондын гэрээний хүрээнд суралцаж төгссөн нийт 47 төгсөгчийн (2022 онд төгссөн 23, 2023 онд төгссөн 19, 2024 онд төгссөн 5) ажил эрхлэлтийн судалгааг хийсэн. Монгол Улсад ажиллаж буй 24 ( төрийн байгууллагад 5, хувийн хэвшилд

18, төрийн бус байгууллагад 1), эх орондоо буцаж ирээгүй, гадаадад ажиллаж буй 7, төгссөн бүртгэл хийлгээгүй 14, гэрээний хугацаанд төгсөөгүй 2 иргэн байна.

**1.4. Багш, сувилагч мэргэжлээр 2021–2026 онд дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад тэтгэлгээр сурсан, суралцаж буй суралцагчдын гэрээний хэрэгжилт, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, гэрээний үүрэг биелүүлээгүй суралцагчдын тоо, олгосон санхүүжилтийн нийт дүн, хийсэн хяналт, шалгалтын талаар;**

Багш мэргэжлээр суралцагчдад 2021–2026 онд нийт 23,903 суралцагчид 45.1 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон. 2025 оны байдлаар багш мэргэжлээр суралцагчдад олгосон тэтгэлгийн хүрээнд 9,085 суралцагчийн гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн байна. Үүнээс 8,069 суралцагчийн гэрээг сунгасан, 748 суралцагч төгссөн, 258 суралцагчийн гэрээг түдгэлзүүлсэн бөгөөд 10 суралцагчийн гэрээг цуцалж, 22.3 сая төгрөгийн тэтгэлгийг буцаан төлүүлсэн байна.

Багш мэргэжлээр төгссөн 748 суралцагчийн ангиллаар авч үзвэл, багш бэлтгэх үндсэн хөтөлбөрөөр суралцсан 247, орон нутагт мэргэжлээрээ ажиллах (хөрвөх) багш 99, багш, ажилтны нэг хүүхэд 59, боловсролын чиглэлээр магистрын хөтөлбөрөөр төгсөгч 200, “өндөр оноо” тэтгэлгээр суралцсан төгсөгч 143 байна. Эдгээр төгсөгчдөөс 345 (46%) нь мэргэжлээрээ ажиллаж байгаа бол 403 (54%) нь мэргэжлээрээ ажил эрхлээгүй байна.

Сувилагч мэргэжлээр суралцагчдад 2021–2026 онд нийт 22,538 суралцагчид 27.0 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон. 2025 оны байдлаар багш мэргэжлээр суралцагчдад олгосон тэтгэлгийн хүрээнд 2864 суралцагчийн гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн байна. Үүнээс 2008 суралцагчийн гэрээг сунгасан, 793 суралцагч төгссөн, 61 суралцагчийн гэрээг түдгэлзүүлсэн бөгөөд 2 суралцагчийн гэрээг цуцалж, 3.2 сая төгрөгийн тэтгэлгийг буцаан төлүүлсэн байна.

Сувилагч мэргэжлээр суралцагчдын хөдөлмөр эрхлэлтийн судалгааг 2026 оны эхний хагас жилд багтаан хийхээр ажиллаж байна.

**1.5. Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад зээл, тэтгэлгээр суралцагчдад олгосон улсын төсвийн хөрөнгийн үр ашгийг тооцсон эсэх, гэрээний үүрэг биелүүлээгүйн улмаас үүссэн алдаа зөрчлийг арилгах чиглэлд хийсэн ажлын талаар;**

Зээл, тэтгэлэгт хамрагдсан суралцагчидтай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх хүрээнд 2025 онд нийтдээ 18206 гэрээг сунгаж 671 түдгэлзүүлж, 31 гэрээг цуцалсан байна. Гэрээний үүрэг зөрчсөн 1894 иргэний 3.4 тэрбум төгрөгийн эргэн төлөлт төвлөрүүлсэн байна.

№		Гэрээ			эргэн төлсөн		Төгссөн
		Сунгасан	Түдгэл зүүлсэн	Цуцалсан	тоо	мөнгөн дүн /тэрбум/	
1	Засгийн газрын тэтгэлэг	32	2				

2	Засгийн газар хоорондын тэтгэлэг	206					7
3	Ерөнхийлөгчийн тэтгэлэг /бэлтгэл/	315		6			
4	Ерөнхийлөгчийн тэтгэлэг /үндсэн/	957	91				8
4	Дэлхийн шилдэг ИС -зээл	166	30	2			
5	Багш мэргэжлээр суралцагч	8069	258	10	10	1.3	748
6	Буцалтгүй тусламж	2466	116	4	4	0.011	610
7	Засгийн газрын тэтгэлэг	1154	76	1	3	0.009	81
8	Зарим эрэлттэй	2499	76	2	2	0.003	901
9	Сургалтын төлбөрийн хөнгөлөлт /орон/	1184	22	3	3	0.006	447
10	Хөнгөлөлттэй зээл				1872	2.05	
11	Оюутны хөгжлийн зээл	1158		3			
	<b>НИЙТ</b>	<b>18206</b>	<b>671</b>	<b>31</b>	<b>1894</b>	<b>3.4</b>	<b>2802</b>

Дээрх арга хэмжээ, хяналтын үр дүнд зээл, тэтгэлгээр олгосон улсын төсвийн хөрөнгийн үр ашгийг гэрээний биелэлт, төгсөлт болон эргэн төлөлтийн үзүүлэлтээр тооцон үнэлэх боломж бүрдсэн бөгөөд гэрээний үүрэг зөрчсөн тохиолдолд санхүүгийн сахилга батыг сайжруулах бодит үр дүн гарсан.

Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан журамд тэтгэлэг, зээл олгох 75 хувийн сурлагын босго-ыг тогтоосон нь дотоодын үнэлгээний системд тохиромжтой боловч, олон улсын их, дээд сургуулиудын ялгаатай үнэлгээний тогтолцоонд шууд дүйцүүлэн хэрэглэхэд иргэдийн гомдол, хэрэгжилтийн маргаан, хүндрэл үүсгэсэн. Цаашид олон улсын их, дээд сургуулиудын үнэлгээний ялгаатай тогтолцоонд нийцсэн шалгуур тогтоох, журамд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж өөрчлөлтийг тусган Засгийн газрын 2026 оны 03 сарын 18-ны өдрийн хуралдаанаар "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" асуудлыг хэлэлцүүлж батлуулсан.

#### **1.6 Боловсролын зээлийн сангийн зээлээр гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцсан иргэдийн зээл, зээлийн хүү, зээлийн эргэн төлөлтийн хугацааг Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүрэн нийлүүлсэн эсэх дэлгэрэнгүй мэдээлэл, тайлбар**

Боловсролын зээлийн сан 2018-оноос хойш оюутны хөгжлийн зээлийн мэдээллийг нийлүүлж байсан бол 2025 оны 4 дүгээр сард Монгол банкны зээлийн мэдээллийн санд дараах мэдээллийг нийлүүлсэн.

1. Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад зээлээр суралцсан 1,406 иргэн бүртгэлтэй байснаас 1,364 төгсөгчийн 77.1 сая ам.долларын зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлсэн бөгөөд 43 төгсөгчийн мэдээлэл дутуу улмаас нийлүүлэх шаардлага хангаагүй. Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад зээлээр суралцсан иргэд зээлдэгчдээс 2025 онд 64 зээлдэгч 957.6 мянган ам.доллар буюу 3.5 тэрбум төгрөгийн зээлийг эргэн төлсөн байна.

2. Дотоодын хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 12,300 иргэнээс 12,128 төгсөгчид хамаарах 13.6 тэрбум төгрөгийн зээлийн мэдээллийг 2025 оны 4 дүгээр сард Монголбанкны зээлийн мэдээллийн санд нэгтгэн хүргүүлсэн байна. Үлдсэн 172 төгсөгчийн зээлийн мэдээлэл дутуу шалтгаанаар мэдээллийн санд нийлүүлэх боломжгүй байна. Мөн зээлийн мэдээлэл нийлүүлснээс хойш 3,478 иргэн 3.8 тэрбум төгрөгийн зээлийг бүрэн төлж барагдуулжээ.
3. Оюутны хөгжлийн зээлийн 2018–2025 оны мэдээллээр нийт 27,186 төгсөгчид хамаарах 92.8 тэрбум төгрөгийн зээлийн мэдээлэл зээлийн мэдээллийн санд бүртгэгдсэн байна. Үүнээс 2018–2025 оны хооронд 7,530 иргэн 15.1 тэрбум төгрөгийн зээлийг төлж барагдуулжээ.

**Асуудал 2. Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтуудаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын биелэлт, өгсөн үүрэг, даалгаврын талаарх мэдээллийг дараах асуултад тус бүрээр:**

**2.1. Засгийн газрын хуралдааны 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 22 дугаартай Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааны талаар авах арга хэмжээний тухай тэмдэглэлд өгсөн үүргийн хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, тайлбар;**

Засгийн газрын хуралдааны 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 22 дугаартай тэмдэглэлд Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаатай холбоотойгоор гадаадад зээлээр суралцаж төгссөн иргэдийн зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд шилжүүлэх үйл ажиллагааны хууль зүйн үндэслэл, үр дагаврыг судалж, үүссэн маргаантай асуудлыг нэгтгэн танилцуулах үүрэг өгсөн.

Уг үүргийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 1997–2026 онд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж төгссөн иргэдийн зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд шилжүүлсэнтэй холбоотойгоор “гэрээний үүргээс чөлөөлөх” асуудлаар иргэдээс ирүүлсэн гомдол, маргааныг судалж эхэлсэн.

Тухайлбал, иргэн Т нь 2001 онд байгуулсан гэрээний дагуу Герман Улсад докторын зэрэг хамгаалж, 2006 оноос хойш Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд тасралтгүй ажилласан бөгөөд 2025 онд түүний зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд нийлүүлсэнтэй холбогдуулан гомдол гаргасан. Уг гомдлыг Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх хянан хэлэлцэхдээ иргэн Т нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн нь нотлогдсон, мөн гэрээний дагуу шаардах эрх Иргэний хуулийн 75.2.1-т зааснаар 3 жилийн дотор хэрэгжих ёстой бөгөөд хөөн хэлэлцэх 10 жилийн хугацаа дууссан тул 2025 онд зээл нэхэмжлэх нь хууль зүйн хувьд боломжгүй гэж дүгнэсэн.

Үүнтэй холбогдуулан Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 1997–2023 онд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж төгссөн, гэрээний үүргээ биелүүлж дуусгавар болсон иргэдийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа болон гэрээний хугацааг дуусгавар болгосон захиргааны актын хууль зүйн үр дагаварт холбогдох мэдээллийг

цуглуулж, дүн шинжилгээ хийж байна. Судалгааны дүнг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар ажиллаж байна.

**2.2. Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаанд хийсэн жил бүрийн буюу 2020–2025 оны аудитын тайлан, 2017–2024 онд үйл ажиллагаанд 2025 оны 5–8 дугаар сарын хооронд хийсэн нийцлийн болон гүйцэтгэлийн аудитын тайлангуудаас тусгасан төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, тайлбар;**

Төлөвлөгөөнд тусгагдсан авах арга хэмжээний хэрэгжүүлэх хугацааг 03 сарын 20-ны байдлаар авч үзвэл хэрэгжүүлэх хугацаа дууссан арга хэмжээ-7, хэрэгжүүлэх хугацаа дуусаагүй, үргэлжлэн хийгдэж байгаа арга хэмжээ-10 байна.

Хэрэгжүүлж хугацаа дууссан 7 арга хэмжээний биелэлт:

- Гадаад зээл: Монгол банканд 2025 оны 04 дүгээр сард 1406 суралцагчийн 78,073,062.98 ам долларын зээлийн хүсэлт илгээснээс 42 суралцагчийн мэдээлэл дутуу нийлүүлэгдээгүй бөгөөд 1364 суралцагчийн 77,130,402.21 ам долларын зээлийн мэдээллийг нийлүүлээд байна.
- Дотоод зээл: Монгол банканд 2018 оноос эхлэн олгож эхэлсэн сургалтын зээлээр суралцсан 27186 суралцагчийн 92.8 тэрбум төгрөгийн, хөнгөлөлттэй зээлээр 2004-2007 онд төгссөн 12299 суралцагчийн 13.7 тэрбум төгрөгийн зээлийн мэдээллийг тус тус нийлүүлсэн.
- Боловсролын зээлийн сан дахь архивын хадгаламжийн нэгжид 516 баримт, архивын нийт 1764 хадгаламжийн нэгжээс Байнга хадгалах 196 ХН, Түр хадгалах 633 ХН, 70 жил хадгалах 873 ХН, Устгах 62 ХН үүсгэсэн байна.
- МУ-ын “Ерөнхийлөгчийн тэтгэлгээр суралцаж буй 208 суралцагчтай тооцоо нийлж баталгаажуулсан. 5 иргэний санхүүжилт зогсоосон. Тооцоо нийлсэн актад гарын үсэг зурж баталгаажуулаагүй. Засгийн газрын 2012 оны 19-р тогтоолын дагуу 12 суралцагч төлж байна.
- Able программыг 2 хэрэглэгчийн эрхтэйгээр гэрээг сунган, ашиглаж байна.
- УАГ-т цахимжуулж өгсөн материалуудыг буцаан авах албан бичгийг 2025 оны 11 дүгээр сард хүргүүлсэн бөгөөд дүгнэлт тайлан байнгын хороогоор ороогүй учир одоогоор ажлын албанд ирээгүй байна.
- Засгийн газрын 2025 оны “Журам шинэчлэн батлах тухай” 215 дугаар тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам”-ын 11.11, 11.12 заалтын дагуу дотоодын дээд боловсролын байгууллагад суралцагчдын гэрээний биелэлтийг дүгнэж дуусгасан. Улмаар дараах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:
  - Зээл төлж дуусгасан 2651 зээлдэгчдийн гэрээг дуусгавар болгосон.
  - 16530 суралцагчийн гэрээг сунгасан.
  - 3 суралцагчийн гэрээг цуцалсан.
  - 548 суралцагчийн гэрээг түр түдгэлзүүлсэн байна.

Үндэсний аудитын газраас “Боловсролын зээлийн сангийн 2017-2024 оны үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэл-нийцлийн аудитын тайланд үндэслэн “Төлбөр барагдуулах тухай” төлбөрийн акт тогтоосон тогтоолын төсөл ирүүлсэнтэй холбогдуулан Н.Должинсүрэнтэй холбогдон Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2.1, 27.4.5, 27.5-т заасныг баримтлан, 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр утсаар болон мэйлээр сонсох ажиллагаа ажиллагаа явуулж, сонсох ажиллагааны тэмдэглэл, баримтыг Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.

**2.3. Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааг цахимжуулах талаар төсөвт тусгасан эсэх, энэ талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар;**

2025 онд Боловсролын яамны санхүүжилтээр 96.5 сая төгрөгийн хөрөнгөөр Сонгон шалгаруулах мэдээллийн системийг боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглаж байна.

Мөн Боловсролын зээлийн сан нь өөрийн үйл ажиллагааны процессуудад дүн шинжилгээ хийж, шаардлагатай системийн модулиудыг тодорхойлон төлөвлөж, үе шаттайгаар хөгжүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

**2.5. Алсын хараа-2050, Засгийн газрын 2024–2028 оны мөрийн хөтөлбөрт Боловсролын хөгжлийн сан бий болгох, мөн Боловсролын зээлийн сангийн статусыг тодорхой болгох ажлыг хэрхэн хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар;**

Боловсролын зээлийн сангийн эрх зүйн статусыг тодорхой болгох, түүнийг Боловсролын хөгжлийн сан болгон өөрчлөн байгуулах чиглэлээр дараах үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

Боловсролын хөгжлийн сангийн эрх зүйн орчны хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлыг Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, доктор, профессор Б.Амарсанаа, тус сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш С.Батбаяр, Монгол Улсын Их сургуулийн Эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн захирал, доктор, профессор Х.Цэвэлмаа нар гүйцэтгэж, 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Боловсролын сайдын ээлжит шуурхай хуралдаанд судалгааны тайланг танилцуулсан.

Судалгааны дүнд Боловсролын зээлийн санг Боловсролын хөгжлийн сан болгон өөрчлөн байгуулахтай холбогдуулан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх, сангийн дүрэм, үндсэн чиг үүргийг тодорхой болгох, санхүүжилт болон эргэн төлөлтийн механизмыг оновчтой болгох талаар саналууд дэвшүүлсэн.

Боловсролын сайдын 2026 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/42 тоот тушаалаар Боловсролын зээлийн санг Боловсролын хөгжлийн сан болгон өөрчлөн байгуулах зорилгоор Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл болон танилцуулгыг боловсруулах, хэлэлцүүлэх,

улмаар Засгийн газрын хуралдаанд танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

**2.6. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Боловсролын зээлийн сангийн нийт 158.4 тэрбум төгрөгийн батлагдсан төсвөөс 33.6 тэрбум төгрөгийг зээлийн эргэн төлөлт болон бусад эх үүсвэрээс бүрдүүлэхээр төлөвлөсөн төлөвлөгөөний хэрэгжилт, бодит гүйцэтгэл, бүрдүүлсэн эх үүсвэрийн бүтэц, үр дүнгийн талаарх мэдээлэл;**

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Боловсролын зээлийн сангийн нийт төсөв 158.4 тэрбум төгрөгөөр батлагдаж, үүнээс 33.6 тэрбум төгрөгийг зээлийн эргэн төлөлт болон бусад эх үүсвэрээс бүрдүүлэхээр төлөвлөсөн.

Тайлант хугацаанд гадаад болон дотоодын зээлийн эргэн төлөлтөөс 17.9 тэрбум төгрөг төвлөрсөн бөгөөд хамтын ажиллагааны хүрээнд Дархан-Уул аймгийн "Төмөрлөг" ХХК, Хот байгуулалт, орон сууцжуулалтын яамтай байгуулсан санамж бичиг, гэрээний дагуу 129.0 сая төгрөгийн бусад эх үүсвэрийг бүрдүүлж, нийт 17.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг бусад эх үүсвэрээс бүрдүүлэн ажилласан. Энэ нь бусад эх үүсвэрээс бүрдүүлэхээр төлөвлөсөн 33.6 тэрбум төгрөгийн 53.6 хувийн гүйцэтгэл юм.

Бүрдүүлсэн эх үүсвэрийн бүтцийг авч үзвэл нийт орлогын 99.3 хувь нь зээлийн эргэн төлөлтөөс, 0.7 хувь нь хамтын ажиллагаа, гэрээний хүрээнд бүрдсэн бусад эх үүсвэрээс бүрдсэн байна.

2025 оны гүйцэтгэлээр Боловсролын зээлийн сангаас нийт 23,289 суралцагчид 108.33 тэрбум төгрөгийн зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламж олгосон бөгөөд үүний санхүүжилтийн тодорхой хэсгийг зээлийн эргэн төлөлт болон бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн нь улсын төсвийн шууд санхүүгийн ачааллыг бууруулахад бодитой хувь нэмэр оруулсан.

Мөн бусад эх үүсвэрээс санхүүжих хяналтын тоог Боловсролын сайдын 2025 оны А/519 дүгээр тушаалаар баталж, дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад тэтгэлэг, зээл олгох зохицуулалтыг тусган ажилласан.

Ингэснээр зээлийн эргэн төлөлт болон бусад эх үүсвэрийг төсвийн санхүүжилттэй уялдуулан ашиглах замаар Боловсролын зээлийн сангийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, улсын төсвийн ачааллыг үе шаттай бууруулах чиглэлээр тодорхой үр дүн гарсан.

**2.7. Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуулиар Боловсролын зээлийн сангийн нийт 278.8 тэрбум төгрөгийн батлагдсан төсвөөс 145.6 тэрбум төгрөгийг зээлийн эргэн төлөлт болон бусад эх үүсвэрээс бүрдүүлэхээр төлөвлөсөн төлөвлөгөөний хэрэгжилт, хэрэгжүүлэхээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, төлөвлөсөн ажлын явц болон хүлээгдэж буй үр дүнгийн талаарх мэдээлэл;**

2026 он гарснаас хойш өнөөдрийн байдлаар гадаадын сургалтын байгууллагад суралцагчдын зээлийн эргэн төлөлт 240 сая төгрөг, дотоодын сургалтын байгууллагад суралцагчдын зээлийн эргэн төлөлт 2,3 тэрбум төгрөг тус тус төлөгдсөн байна.

Одоогийн авлага 241 тэрбум төгрөг байгаагаас зээлийн эргэн төлөлтийг сайжруулахын тулд гадаадын сургалтын байгууллагад суралцаж төгссөн иргэдийн гэрээг дүгнэх, график гаргаж зээлээ төлөхийг шаардах, төлөхгүй байгаа иргэдийг шүүхэд нэхэмжлэл гаргаж төлүүлэх, Хуулийн багтай гэрээ байгуулан хамтран ажиллах саналыг Боловсролын яаманд хүргүүлэхээр ажиллаж байна.